

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОН

ОЮУ ТОЛГОЙ ХХК

ХООРОНДЫН БАЙГУУЛСАН

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ГЭРЭЭНИЙ  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ГЭРЭЭ

2020 он

## Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай гэрээний

### Нэмэлт, өөрчлөлтийн гэрээ

#### 1 Гэрээний талууд

- (a) Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Эрчим хүчний сайд Цэрэнпилийн Даваасүрэн, мөн Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Алмаликийн Тлейхан (**Засгийн газар**), болон
- (b) Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 15, Моннис цамхаг 12 дугаар давхарт байрлах "Оюу толгой" ХХК-ийг төлөөлж ТУЗ-ийн дарга Галсангийн Батсүх, Гүйцэтгэх захирал Армандо Торрес (**ОТ ХХК**).

#### 2 Үндэслэл

- (a) ОТ төслийг цахилгаан эрчим хүчээр хангахын тулд ТТЦС эсвэл бусад дотоодын эх үүсвэрүүдийг барьж байгуулах зорилгоор Засгийн газар болон ОТ ХХК нь "Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай гэрээ" (**ЭХЭҮЗТГ**)-г 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан. Энэхүү гэрээнд ашигласан нэр томъёонууд нь ЭХЭҮЗТГ-ний нэр томъёотой ижил утгатай байна.
- (b) Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаанаар төрийн өмчийн хөрөнгөөр Таван толгойн цахилгаан станц (**ТӨЦС**)-ыг барьж, эрчим хүчээр ОТ Төслийг хангах тухай 124 дүгээр тогтоолыг гаргасан.
- (c) Энэхүү гэрээнд заасны дагуу ТӨЦС-ыг тэргүүнд ээлжид хөгжүүлэх, (дор тодорхойлсон) ТӨЦС-ын ЦЭХХАГ-г байгуулахаар ажиллах, ЦЭХХАГ-г байгуулснаар ЭХЭҮЗТГ-г дуусгавар болгох ба үүнээс үүдэн ЭХЭҮЗТГ-нд тодорхой нэмэлт, өөрчлөлтийг оруулж, ЭХЭҮЗТГ-ний хэрэгжилтийг түдгэлзүүлэхээр талууд харилцан тохиролцов.

#### 3 ЭХЭҮЗТГ-нд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг түдгэлзүүлэх, дуусгавар болгох болон ТӨЦС-ыг тэргүүлэх чиглэл болгох тухай

- (a) Энэхүү гэрээг байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох, ЭХЭҮЗТГ-ний нэгэн адил хүчинтэй дараах заалтуудыг талууд харилцан тохиролцов (дараах заалтуудын дагуу авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь ЭХЭҮЗТГ-г мөн хэрэгжүүлж байгаа хэлбэр болно). Үүнд:
  - (i) ЭХЭҮЗТГ-ний 7.4(b)-д заасан хоёр дахь 2 (хоёр) сарын хугацааг ТӨЦС-ын ажлуудаас графикт хугацаандаа хэрэгжээгүй (үүнд 3(a)(ii)(C)(2) дахь заалтад заасан буюу ТӨЦС-ын ЦЭХХАГ-г байгуулахаас бусад графикт ажил хамаарна) эхний тохиолдол хүртэл түдгэлзүүлж байна;
  - (ii) ЭХЭҮЗТГ-ний бусад заалтыг хязгаарлахгүйгээр:
    - (A) талууд 3(a)(iv) дахь заалт хэрэгжих хүртэл ТӨЦС-ыг чухалчлан үзэж, тэргүүн ээлжид хөгжүүлнэ,
    - (B) ТӨЦС-аас ОТ ХХК-ийг цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор талууд, Холбогдох байгууллага нарын хооронд

байгуулах Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ (ТӨЦС-ын ЦЭХХАГ)-ний төслийн хэлэлцээрийг хийнэ;

(C) ТӨЦС-ын хувьд дараах тохиролцсон хугацааны график (ТӨЦС-ын графикт хугацаа) үйлчилнэ. Үүнд:

- (1) 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хэтрүүлэхгүйгээр 3(b) заалтад дурдсан сунгалтын гэрээг байгуулах,
- (2) 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс хэтрүүлэхгүйгээр ТӨЦС-ын ЦЭХХАГ-г байгуулах,
- (3) 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэтрүүлэхгүйгээр ТӨЦС-ын барилга угсралтын ажлыг эхлүүлэх,
- (4) Барилга угсралтын ажлыг эхлүүлснээс хойш 48 сарын дотор ТӨЦС-ыг ашиглалтад оруулж, ТӨЦС-аас ОТ Төслийг найдвартай, тасралтгүй эрчим хүчээр хангаж эхлэх.

(iii) ТӨЦС-ын ЦЭХХАГ-нд дараахыг тусгана. Үүнд:

(A) ТӨЦС-ын ЦЭХХАГ-г байгуулмагц талуудын харилцан тохиролцсон нөхцөлөөр ЭХЭҮЗТГ-г дуусгавар болгоно.

(B) (1) найдвартай, тасралтгүй цахилгаанаар 20 жилээс багагүй урт хугацаагаар хангана, (2) ТӨЦС-ын ЦЭХХАГ-нд тодорхойлогдсон харилцан зөвшилцсөн, өрсөлдөхүйц тарифаар эрчим хүч нийлүүлнэ, (3) ОТ ХХК эсхүл ОТ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдээс аливаа санхүүжилт эсхүл санхүүжилтийн дэмжлэг шаардахгүй, мөн (4) ОТ ХХК нь тэргүүн ээлжинд ТӨЦС-аас эрчим хүч авах ба нөөц эх үүсвэрүүдийг зөвхөн ТӨЦС-ын эрчим хүч нийлүүлэх хүчин чадал хүрэлцэхгүй болсон тохиолдолд ашиглана, (5) Засгийн газар ОТ ХХК нь ОТ ХөОГ-ний дагуу ажиллаж байгааг хүлээн зөвшөөрнө, түүнчлэн (6) хэрэв ТӨЦС хэрэгжихгүй болсон эсвэл ТӨЦС-ын ЦЭХХАГ-г хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд ОТ ХХК нь ОТ Төслийг эрчим хүчээр хангах дотоодын эрчим хүчний өөр шийдлийг (3(a)(iv)-д заасан сонголтуудаас) хэрэгжүүлэх эрхтэй байна.

(iv) 3(a)(iii)(B)(6) дахь заалтыг харгалзан, хэрэв:

(A) 3(a)(ii)(C) дэх заалтын дагуу ТӨЦС-ын аливаа ажил (үүнд 3(a)(ii)(C)(2) дахь заалтад заасан буюу ТӨЦС-ын ЦЭХХАГ-г байгуулахаас бусад графикт ажил хамаарна) заасан графикт хугацаандаа (эсвэл талуудын бичгээр харилцан тохиролцсон өөр өдөр гэхэд) хэрэгжээгүй, гэхдээ уг хугацааг Засгийн газрын хяналтаас гадуур Хугацаа хэтрэхэд хүргэсэн нөхцөл байдлаас шалтгаалан сунгаж болно, эсвэл

(B) Засгийн газар ТӨЦС-ыг цаашид үргэлжлүүлэхгүй болсон тухайгаа албан ёсоор зарласан эсхүл ОТ ХХК-д бичгээр мэдэгдсэн, бол

түүнээс хойш ОТ ХХК нь ЭХЭҮЗТГ-ний 7.4(b)-д заасан эрчим хүчний шийдлийг ЭХЭҮЗТГ-ний нөхцөлүүдийн дагуу хэрэгжүүлж болох ба хэрэгжүүлэх эрхтэй байна. Энэ тохиолдолд ОТ ХХК уг шийдлийн барилга угсралтын ажлыг энэхүү 3(a)(iv) дэх заалтын (А) эсхүл (В) дэд хэсэг үйлчилсэн өдрөөс хойш 48 сарын дотор дуусгах ба Хугацаа хэтрэхэд хүргэсэн нөхцөл байдлаас шалтгаалан сунгаж болно.

- (b) Талууд холбогдох ТӨЦС-ын графикт хугацаанд багтаан (2023 оны 7 дугаар сарын 23-ны өдөр дуусгавар болох) одоогийн импортын эрчим хүчээр хангах гэрээнүүдийг дуусгавар болох өдрөөс эхлэн ОТ ХХК-ийн тодорхойлж, ӨМЭХК-тай хэлэлцэн тохиролцох хугацаагаар сунгахаар үнэнч шударгаар мэрийн, энэхүү гэрээг байгуулснаас хойш дөрвөн долоо хоногийн дотор даруй хамтран ажиллаж эхлэх ба ОТ Төслийн одоогийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтад (үүнд "гүний уурхайн хүдрийн биетийн улаар таслах шийдвэр" орно) тасалдал үүсгэхгүй байх үүднээс дотоодын эх үүсвэрээс ОТ ХХК-ийг хангах эрчим хүч нь (ТӨЦС-ын ЦЭХХАГ-нд харилцан тохиролцсон шалгалт, туршилтын ажиллагааны дагуу) найдвартай, тасралтгүй, тогтвортой болохыг батлан харуулмагц, түүнийг тэргүүлэх чиглэл болгохоор уг сунгалтын гэрээнүүдийг хамгийн боломжит ойрын хугацаа болох 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэхэд цуцлах боломжтой байхаар уг гэрээнд зааж өгнө.
- (c) Энэхүү гэрээгээр тусгайлан өөрчлөлт оруулаагүй бол ЭХЭҮЗТГ-ний заалтууд хүчин төгөлдөр хэвээр үйлчлэх ба эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс ТӨЦС-ын хувилбарт ЭХЭҮЗТГ-ний 4.1(b)(ii), 4.3(c) заалтууд үйлчлэхгүй болно.

#### 4 Бусад заалт

- (a) Засгийн газар уг гэрээгээр амласан, зөвшөөрсөн, тохиролцсон асуудлуудыг хууль ёсны гэдгийг баталж, энэхүү гэрээ нь (одоогийн болон дараагийн Засгийн газруудын хувьд, түүний дотор яам, агентлаг, засгийн газрын байгууллагын бүх түвшинд) хууль ёсны заавал дагаж мөрдөх шинжтэй байх ба энэхүү гэрээнд гарын үсэг зурах этгээдүүд нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 201 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж, Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс энэхүү гэрээг байгуулах хууль ёсны эрхтэй болохыг баталж, баталгаажуулж байна.
- (b) ОТ ХХК уг гэрээгээр амласан, зөвшөөрсөн, тохиролцсон асуудлуудыг хууль ёсны гэдгийг баталж, энэхүү гэрээ нь хууль ёсны заавал дагаж мөрдөх шинжтэй байх ба энэхүү гэрээнд гарын үсэг зурах этгээдүүд нь ОТ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрхийн дагуу ОТ ХХК-ийг төлөөлж, ОТ ХХК-ийн нэрийн өмнөөс энэхүү гэрээг байгуулах хууль ёсны эрхтэй болохыг баталж, баталгаажуулж байна.
- (c) ЭХЭҮЗТГ-ний 9, 10(b), 10(f) дахь заалтуудыг энэхүү гэрээнд бүхэлд нь тусгасны адилаар ойлгож, энэхүү гэрээний нэг хэсэг гэж үзэхийг Талууд зөвшөөрч байна.

Энэхүү гэрээг 2020 оны 6 дугаар сарын \_\_\_\_\_ өдөр байгуулав.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ төлөөлж хууль ёсны эрх бүхий төлөөлөгч:**

**Цэрэнпилийн Даваасүрэн**  
Эрчим хүчний сайд

**Алмаликийн Тлейхан**  
Эрчим хүчний зохицуулах хорооны  
дарга

Гарын үсэг:

Гарын үсэг:

Огноо:

Огноо:

**“Оюу толгой” ХХК-ийг төлөөлж хууль ёсны эрх бүхий төлөөлөгч:**

**Галсангийн Батсүх**  
ТУЗ-ийн дарга

**Армандо Торрес**  
Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

Гарын үсэг:

Огноо

Огноо: